



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ХК-ийн
үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 7.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 342,353,000 /гурван зуун дөчин хоёр сая, гурван зуун тавин гурван мянга/ ширхэг энгийн хувьцааг хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсэнтэй нь холбогдуулан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 372,123,927 /гурван зуун далан хоёр сая нэг зуун хорин гурван мянга есөн зуун хорин долоо/ ширхэг энгийн хувьцаа байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ХК /Г.Дамдинсүрэн/-д үүрэг болгосугай:

1/ Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллах;

2/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөж ажиллах.

000055

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН